

“ Э-ТРАНС ЛОЖИСТИКС “ ХК-НЫ 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

- **Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг;**
Хаяг: Дорноговь аймаг, Замын Үүд сум, 1-р баг, Төмөр замын өргөн чөлөөний гудамж, 04-411 тоот Э-Транс ложистикс ХК-ны байр Утас: 02524543813, 99117636, 99991451
Электрон хаяг: www.etr.mn
- **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл;**
Компанийн нэр: “ Э-транс Ложистикс “ ХК
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо: 2011.12.06
Улсын бүртгэлийн дугаар: 0610001001
Регистрийн дугаар: 3309665
Үйл ажиллагааны чиглэл: Ачаа шилжүүлэн ачих терминал
Хувьцаа эзэмшигчдийн тоо:
- **Товч танилцуулга;**



Э-Транс ложистикс Хувьцаат компанийн хяналтын багцыг эзэмшигч Э-Транс Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь 2007 оноос Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1-р багийн нутагт төмөр зам дагасан байрлалд салбар зам барин ачаа шилжүүлэн ачих терминал байгуулах төсөл хэрэгжүүлснээр манай компанийн үйл ажиллагааны эхлэл тавигдсан.

2007-2008 онд шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтыг хийж ашиглалтанд оруулсан бөгөөд 2009 оны 4 дүгээр сард анхны тээврийн хэрэгслээс вагонд шилжүүлэн ачих ажлыг хийж гүйцэтгэсэн.

2010 онд шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагааг тусгаарлан Э-Транс ложистикс хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлсэн.

2012 оны 04 сард Монголын Хөрөнгийн бирж дээр бүртгүүлэн хувьцаат компани болсон ба 924 сая төгрөгийн хөрөнгө оруулалт татан техник тоног төхөөрөмж, барилга байгууламж, дэд бүтцээ сайжруулах, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулсан.

2011 онд Э-Транс ложистикс ХХК-нд үйл ажиллагаа нь шилжин ирсэнээс хойш нийт **25,509** вагон буюу **1,632,576** тонн ачааг шилжүүлэн ачиж харилцагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн захиалгын дагуу түргэн шуурхай, найдвартай хүргүүлж ажилласан байна.

1. КОМПАНИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

1.1 Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;

2020 оны 04 дүгээр сарын 29-нд цахимаар хуралдсан компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг баталсан бөгөөд төлөвлөгөөгөөр компанийн үйл ажиллагааг сайжруулах, ашиг орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн 17 ажлыг 2020 оны ажлын жилд хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажилласан. 2020 онд улс орны хэмжээнд цар тахлын нөхцөл байдал хүнд эдийн засгийн боломж бололцоо тааруу байсны улмаас бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн шинэчлэлт, засвар үйлчилгээ зэрэг хөрөнгө мөнгө шаардлагатай ажлуудыг хийх боломжгүй байсан. Гэвч энэ нөхцөл байдалд тохируулан цаашид авч хэрэгжүүлэх ажлуудыг тухай бүр салбар төлөвлөгөө гарган ажиллаж бизнес төлөвлөгөөгөөр хийж гүйцэтгэхээр заасан ажлуудыг буюу гол төлөв судалгааны ажлуудыг 50-70 хувьтай биелүүлсэн гэж үзсэн.

1.2. Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь;

Компани нь эрхэлж байгаа үйл ажиллагааныхаа хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь ижил төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгжүүдтэй өрсөлдөх чадамжийн хувьд өмнөх жилүүдийнхтэй адил түвшинд байгаа гэж үнэлж болно. Өнөөдрийн байдлаар ачаа шилжүүлэн ачих терминал буюу төмөр замаар ачаа тээвэрлэх үйл ажиллагаа Улаанбаатар төмөр зам ХНН-ийн үйл ажиллагаанаас хараат байдлаар ажиллаж байгаа нь компанийн шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагааг ихээр доголдуулж байгаа боловч гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын үйлчилгээгээр бусад аж ахуйн нэгжүүдээс давуу байдалтай ажиллаж байгаа нь компанийн үйл ажиллагааг хэвийн хэмжээнд явуулах бололцоог олгож байна. Тайлангийн хугацаанд Замын-Үүд хилийн боомт, түүнийг дагасан зарим гаалийн хяналтын бүсийн шинэчлэлтийн ажил хийгдэж байгаатай холбоотой тухайн боомтод ажиллаж байсан гол хяналтын бүсийн (төрөл бүрийн ачаа) ачаа барааны хяналтыг тус компанийн гаалийн хяналтын бүсэд шилжүүлснээр хяналтын бүсийн үйл ажиллагаа 2 дахин нэмэгдсэн. Ингэж гол ачааны гаалийн хяналтыг тус компанид шилжүүлж байгаа нь эрхэлж байгаа үйл ажиллагаагаа маань бүс нутагтаа хэрхэн үнэлэгдэж байгаа нь харагдаж байгаа юм.


1.3. Компанийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл;

Компанийн гол үйлчилгээ болох шилжүүлэн ачилт Замын-Үүд өртөөний үйл ажиллагаанаас шалтгаалан өмнөх жилүүдийнхээс ихээхэн доголдох болсон. Вагоны хангалт, ачаа татах ажлууд удааширснаас тус салбар замаар шилжүүлэн


ачилт хийлгэх хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж улам буурсаар байгаа нь цаашид шилжүүлэн ачилтын үйлчилгээг ажлуулахад бэрхшээлтэй эрсдэлтэй нөхцөл байдал үүсэж байна.

Ачилтыг ачааны төрлөөр нь ялгаж харуулсан нь:

2020 ОНЫ АЧИЛТ / ТӨРЛӨӨР /



2019, 2020 онуудын ачилтыг харьцуулсан байдал



Дээрх хүснэгт, графикаас харвал цементийн ачилт хийгдсэн үе болох 5-6 саруудад нэлээн өссөн боловч энэ төрлийн ачилт дуусмагц огцом буурсан нь харагдаж байна. 2020 он гарсаар шилжүүлэн ачилтын нөхцөл байдал өмнөх жилүүдийнхээс бага хэмжээгээр сэргэж байсан боловч төмөр замын байгууллагын үйл ажиллагаанаас хараат байдаг байдлаас шалтгаалан тогтвортой бүрэн дүүрэн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгжид хүргэж чадахгүйд хүрч үйлчлүүлэгчгүй болох нөхцөл байдалтай тулгарч байна. Иймд цаашид учирч болох эрсдлээс урьдчилан


сэргийлэх, шилжүүлэн ачилтын нөхцөл байдлыг сайжруулах үүднээс тодорхой бодлого боловсруулж ажиллахаар гүйцэтгэх удирдлагаас шийдвэрлэсэн.

1.4. Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл;

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас улс орны хэмжээнд онц байдал зарлагдан хорио цээрийн дэглэм хэрэгжиж хил хаагдсан зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж экспорт, импортын үйл ажиллагаа саатсан бөгөөд Засгийн газрын зүгээс холбогдох арга хэмжээнүүдийг тухай бүр авч хэрэгжүүлснээр энэ байдал арилж одоо хэвийн хэмжээнд явагдаж байна. Экспортоор гаргаж байгаа мах, махан бүтээгдэхүүнийг Улаанбаатар хотод гаалийн хяналт хийж шууд Эрээн хот хүртэл тээвэрлэж байх шийдвэр гарсантай холбоотой хяналт шалгалтыг тус хяналтын бүсэд хийхгүй болж 2018, 2019 онуудад нийт 57,8 сая төгрөгний орлого олж байсан үйлчилгээ хэрэгжихээ больсон. Гэхдээ мах махан бүтээгдэхүүнээс бусад экспортонд гарч байгаа ачаа барааны хяналт шалгалт тус гаалийн бүсээр хийгдэж байгаа юм.



Пүүлсэн экспортын ачааны тоо

Он	Экспортын ачааны тоо		Пүүлсэн үйлчилгээний хураамж	
	2019 он	2020 он	2019 он	2020 он
1 сар	147	41	2,672.7	745,454
2 сар	36	15	654.5	272,727
3 сар	102	37	1,854.5	672,727
4 сар	154	51	2,800.0	927,272
5 сар	170	40	3,090.9	727,273
6 сар	144	40	2,618.2	727,273
7 сар	181	30	3,290.9	681.8
8 сар	214	37	3,890.9	1,190.9
9 сар	176	78	3,200.0	2,172.7
10 сар	456	78	8,290.9	3,240.9
11 сар	249	51	4,527.3	1,390.9
12 сар	526	38	9,563.6	1,209.1
Нийт	2555	554	46,454.5	15,447.6



Төмөр замаар ирж Хятад улс руу экспортлогддог түүхий эдийг шилжүүлэн ачих ажиллагаа (буулгалт) нь 2012 оноос тогтмол буурч 2019 оноос хойш тасарсан.


Гаалийн хяналтын бүсэд Замын-Үүд хилийн боомт дахь Авто замын шалган нэвтрүүлэх цэгийн гаалийн хяналтын бүсийн АЗШНЦ-т шалгагдаж байсан төрөл бүийн ачааны гаалийн хяналт шалгалт 2020 оны 02 дугаар сард шилжиж ирснээр тус гаалийн бүсийн ачаалал 2 дахин нэмэгдэж үүнийг дагаад орлого нэмэгдсэн. Сүүлийн жилүүдэд импортын техник тоног төхөөрөмж уул уурхай ялангуяа БНХАУ луу гарч байгаа нүүрсний импорт ихсэх хандлагатай байгаатай холбоотой тээврийн болон уурхайн тоног төхөөрөмжүүд импортоор орж гаалийн бүрдүүлэлтээ хийлгэх мөн гаалийн баталгаат агуулахад түр хадгалуулах үйлчилгээ нэмэгдлээ.



Гаалийн хяналтын бүсэд гаалийн бүрдүүлэлт хийхээр нэвтэрсэн машины тоо хураамж

Сар	Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл		Хяналтын бүс болон агуулахад ачаа бараа хадгалсны хураамж
	Тоо	Хураамж	
1 сар	378	12,280,000	93,334,400
2 сар	204	7,729,091	61,553,980
3 сар	935	9,801,818	53,429,480
4 сар	1288	13,578,182	21,281,916
5 сар	1352	14,515,454	13,436,800
6 сар	1358	16,041,818	19,552,445
7 сар	1449	18,870.0	4,613.2
8 сар	1817	32,145.4	
9 сар	1907	49,357.3	87,227.9
10 сар	1780	51,921.8	173,063.9
11 сар	1328	40,972.8	23,342.2
12 сар	276	7,036.4	87,713.7
Нийт дүн	14,072	274,340.0	669,406.4

Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл



Орлогыг нэр төрлөөр нь харуулсан нь / мян төгрөг /

д/д	Орлогын нэр	2019 он	2020 он	Зөрүү	Өсөлт/ бууралт
1	Ачилтын орлого	89,620.2	78,103.04	-11,517.1	14.7% буурсан
2	Буултын орлого	1,200.0	0	-1,200	100% буурсан
3	Хадгалалт болон гарах хуудас	490,790.1	943,746.3	452,956.2	92.3% өссөн
4	Түрээсийн орлого	45,772.7	41,818.8	-3,953.9	9.45% буурсан
5	Бусад орлого	264,231.9	180,100.1	-84,131.8	46.7% буурсан

2020 оны орлогын байдлаас харвал компанийн үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачилт тодорхой хэмжээгээр буурсан ч гаалийн хяналтын бүс дэх үйл ажиллагаанаас олох орлого өмнөх жилийнхээс огцом өссөн нь харагдаж байна. Энэ өсөлт нь дээр дурьдсан хяналтын бүсэд бүрдүүлэлт хийгдэх ачаа барааны төрөл нэмэгдсэн болон бусад хүчин зүйлээс шалтгаалсан болно. Харин түрээсийн болон бусад орлого буурсан нь Ковид-19 цар тахалтай холбоотой хөл хорио тогтоосон, түрээсийн орлого бууруулсан зэрэг хүчин зүйлээс шалтгаалсан гэж үзэж байна.

1.5 Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан


Тус компани нь үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагтаа буюу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь байгууллага, аж ахуйн нэгжийн дунд томоохонд орох татвар төлөгч аж ахуйн нэгж юм. Компанийн үйл ажиллагааны одоогийн байдал, ирэх жилүүдийн үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөнүүдээр компани нь цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах бүрэн боломжтой бөгөөд энэ талаараа жил бүрийн хувьцаа эзэмшигчдэдээ тайлагнан ажиллаж байна.

2015-2020 онд төлсөн татварын хэмжээг хүснэгтээс харвал:

Татварын төрөл	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Үл хөдлөх хөрөнгийн орлогийн албан татвар	47,953,936	28,556,365	17,940,365	40,330,275	19 730 269	23 637 1
Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	574,900	482,275	299,940	534,540	981 450	812 1
Газрын төлбөр	400,000	400,000	400,000	400,000	7 500 000	14 720
Нэмэгдсэн өртгийн орлогын албан татвар	43,335,267	59,446,662	39,042,992	38,000,000	62 040 928	111 265 1
Хувь хүний орлогын албан татвар	20,397,566	22,411,896	12,989,953	24,729,833	22 172 326	14 833 1
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	27,623,094	122,285	0	4,643		3 460 0
Нийт дүн	140,284,763	111,419,483	70,673,250	103,999,291	112,424,973	168,727,4

Жич: Голлох татварын хэмжээг харуулав.

Үүнээс гадна нийгмийн даатгалын санд төлсөн даатгалын шимтгэлийг харвал:



ЗГ-аас Ковид-19 цар тахлын үед аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагааг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зарим хөнгөлөлтийг үзүүлэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийгмийн даатгалын санд төлөх даатгалын шимтгэлийг хөнгөлсөн тул 2020 онд төлсөн татвар 2 дахин буурсан байна.

1.6 Нийгмийн хариуцлагын тайлан

Замын-Үүд суманд үйл ажиллагаагаа явуулахад ажиллах хүчний тогтвор суурьшил муу, шилжилт хөдөлгөөн их байдагтай холбоотойгоо ажлын тасралтгүй

үйл ажиллагаа явуулах нөхцөл байдал доголдолтой байдаг нь ажилд сөргөөр нөлөөлдөг. Иймээс бид орон нутгийн харъяат иргэдээс залуу боловсон хүчнийг сургах, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэн компанидаа ажилуулах тал дээр ихээхэн анхаарч ажиллаж байна. 2020 оны ажлын жилд тус компани нийт 34 ажилчидтай ажилласан бөгөөд эдгээрийн 29 нь буюу нийт ажилчдын 85,2%-ийг Замын-Үүд суманд оршин суудаг, сумын харъяат иргэд эзэлж байгаа бөгөөд үлдсэн 5 буюу 14,8%-ийг түр оршин суугч иргэд эзэлж байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЗДТГ, Замын-Үүд сумын 1-р багтай нягт хамтран ажиллаж байна. Энэ онд сум орон нутагт Ковид-19 цар тахлын өвчлөл гарч хатуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан сумын Онцгой комиссын үйл ажиллагааг дэмжих зорилгоор мөнгөн хандив тусламж, 1-р багийн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн хүүхдүүдэд зориулж тусламж, ажилчдийнхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд түлхэц үзүүлэх үүднээс нийт ажилчдын цалинг 10-30 хүртэлх хувиар нэмэгдүүлж, цаашид идэвх зүтгэлтэй тогтвор суурьшилтай ажиллах ажилчдын хүүхдийн сургалтын төлбөрийг төлөх, ахмадын баяраар тэтгэвэрт гарсан өндөр настан болон 1-р багийн өндөр настнуудад гарын бэлэг гардуулах зэрэг ажлуудыг хийхээс гадна ажилчдынхаа цаашид ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх үүднээс оны эцэст ажилчдын ажлыг үнэлж дүгнэн 5 ажилчинг хөдөлмөрийн аварга ажилтнаар шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнасан.

2. УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2.1. Компанийн удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;

Компанийн удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй болно.

2.2. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл;

Гүйцэтгэх удирдлага

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол, мэргэжил	Ажлын туршлага
1.	Чулуун Амарсанаа	Гүйцэтгэх захирал	Дээд, уулын инженер	Тус компанийг үүсгэн байгуулсан.
2.	Эрдэнэбаатар Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Дээд, математикч, нягтлан бодогч	2011 оноос хойш ажиллаж байна.
3.	Хаваан Батхишиг	Менежер	Дээд, бизнесийн удирдлага	2012 оноос хойш ажиллаж байна.
4.	Гомбо Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Дээд, багш	2011 оноос хойш ажиллаж байна.
5.	Ванданлхүндэв Баасансүрэн	Ачаа тээврийн ахлах мэргэжилтэн	Дээд, Эрүүл ахуйч	2011 оноос хойш ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн 2018 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгосон.

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1.	Энхболдын Батболд	ТУЗ-ын дарга, хараат гишүүн	Дээд	Э-Транс ХХК, Дэд захирал
2.	Чулууны Энхболд	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Э-Транс ХХК, Ерөнхий захирал
3.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Э-Транс Ложистикс ХК, Гүйцэтгэх захирал
4.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, Тэргүүн дэд захирал
5.	Данзангийн Даянбилгүүн	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, Гүйцэтгэх захирал
6.	Шараагийн Шинэбаяр	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, хөрөнгө оруулалтын менежер
7.	Алтангэрэлийн Цэнгэл	ТУЗ-ын хараат бус гишүүн	Дээд	Рейлнет ХХК, Дэд захирал
8.	Жаргалсайханы Энхтулга	ТУЗ-ын хараат бус гишүүн	Дээд	Лайф ис Гүүд Монголиа ХХК, нягтлан бодогч
9.	Чулуунбаатарын Оргил	ТУЗ-ын хараат бус гишүүн	Дээд	Хувиараа

2.3 Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл

д/д	Овог нэр	Албан тушаал	Цалин урамшууллын хэмжээ	Эзэмшиж буй хувьцааны тоо
Төлөөлөн удирдах зөвлөл				
1.	Энхболдын Батболд	ТУЗ-ын дарга, хараат гишүүн	0₮	Эзэмшдэггүй
2.	Чулууны Энхболд	ТУЗ-ын хараат гишүүн	0₮	Эзэмшдэггүй
3.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын хараат гишүүн, гүйцэтгэх захирал	сарын 1.500.000	Эзэмшдэггүй
4.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын хараат гишүүн	0₮	Эзэмшдэггүй
5.	Данзангийн Даянбилгүүн	ТУЗ-ын хараат гишүүн	0₮	Эзэмшдэггүй
6.	Шараагийн Шинэбаяр	ТУЗ-ын хараат гишүүн	0₮	Эзэмшдэггүй
7.	Алтангэрэлийн Цэнгэл	ТУЗ-ын хараат бус гишүүн	0₮	Эзэмшдэггүй
8.	Жаргалсайханы Энхтулга	ТУЗ-ын хараат бус гишүүн	0₮	Эзэмшдэггүй

9.	Чулуунбаатарын Оргил	ТУЗ-ын хараат бус гишүүн	0₮	Эзэмшдэггүй
Гүйцэтгэх удирдлага				
1.	Эрдэнэбаатарын Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Сарын 1.500.000₮	Эзэмшдэггүй
2.	Хавааны Батхишиг	Менежер	Сарын 1.500.000₮	Эзэмшдэггүй
3.	Гомбын Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Сарын 1.300.000₮	Эзэмшдэггүй
4.	Ванданлхүндэвийн Баасансүрэн	Ачаа тээврийн ахлах мэргэжилтэн	Сарын 1000.000₮	Эзэмшдэггүй

2.4. ТУЗ болон түүний дэргэдэх хороод

д/д	Овог нэр	Эзэмшсэн мэргэжил, боловсрол	Хараат бус гишүүн эсэх	ТУЗ-ын хороодод томилогдсон байдал
1.	Энхболдын Батболд	Тайваны их сургууль, эрх зүйч	Хараат	Нэр дэвшүүлэх хорооны дарга
2.	Чулууны Энхболд	Ленинградын Төмөр замын дээд сургууль, Төмөр замын инженер	Хараат	
3.	Чулууны Амарсанаа	ЗХУ-ын Свердловск хотын Уулын дээд сургууль, Уулын инженер	Хараат	
4.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ШУТИС, нефтийн инженер	Хараат бус	Аудитын хорооны дарга
5.	Данзангийн Даянбилгүүн	Санхүү эдийн засгийн дээд сургууль, бизнесийн удирдлага	Хараат	Цалин урамшууллын хорооны дарга
6.	Шараагийн Шинэбаяр	Сэрүүлэг дээд сургууль, бизнесийн удирдлага	Хараат	
7.	Алтангэрэлийн Цэнгэл	ИрГУПС, Удирдлагын академи	Хараат	Нэр дэвшүүлэх хороо, аудитын хорооны гишүүн
8.	Жаргалсайханы Энхтулга	Санхүү эдийн засгийн дээд сургууль, бизнесийн удирдлага	Хараат бус	Аудитын хороо, цалин урамшууллын хорооны гишүүн
9.	Чулуунбаатарын Оргил	Chinese Culture University, Магистр, мэдээллийн удирдлагын систем	Хараат бус	Нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хорооны гишүүн

2.5. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан

2020 онд компани нь дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас хилийн болон улс орон доторх хөл хорио, үйл ажиллагааг хязгаарласан, хаасан хүндхэн нөхцөл байдалд ажиллаж компанийн гүйцэтгэх удирдлага, ажилчин алба хаагчдын

хүчин чармайлтаар энэхүү хүнд цаг үеийг гарз хохиролгүй даван тууллаа гэж дүгнэж байна.

Тайлангийн хугацаанд компанийн үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачилт өмнөх оны мөн үеийнхтэй ажил байсан боловч ачилтын дийлэнхийг эзэлж байгаа цемент (221 вагон) ачигдаагүй бол ачилтын нөхцөл байдал ихээхэн буурсан үзүүлэлт гарах байсан.

Шилжүүлэн ачилтын нөхцөл байдал ийм тааруу үзүүлэлттэй байгаа ч бусад үйл ажиллагаа буюу гаалийн хяналтын бүс дэх үйл ажиллагаагаа өмнөх жилүүдэд байгаагүйгээр ачаалалттай ажиллаж үүнийг дагаад ч энэ үйлчилгээнээс олох орлого 2019 оны дүн мэдээнээс 92,3%-иар өссөн үзүүлэлттэй гарлаа.

Гаалийн хяналтын бүсэд Замын-Үүд боомт дахь шинэчлэлтийн ажил хийгдэж байгаатай холбоотой төрөл бүрийн ачааны гаалийн хяналт шалгалтыг шилжүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан тус компанийн гаалийн нэг цэгийн үйлчилгээнд ажиллах гааль, мэргэжлийн хяналтын байцаагч нарын өрөө, тасалгаа, байцаагч нарын ажиллах таатай нөхцөл байдлыг хангах, ажил үйлчилгээндээ ашиглах зарим тоног төхөөрөмжийг авах зэрэг ажилд тодорхой хэмжээний хөрөнгө гаргаж зарцууллаа.

Мөн хяналтын бүсийн үйл ажиллагааны чанар, нөхцөл байдлыг сайжруулах, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах үүднээс хяналтын талбайн зарим хэсгийг бетонон хавтангаар солих ажлыг үргэлжлүүлэн 2019 онд 61 ширхэг хавтанг 63 сая төгрөгөөр, 2020 онд 34 хавтанг 21,583,000 төгрөгийн зардал гарган компанийн ажилчдын хүчээр сольж тавьлаа. Цаашид мөн тодорхой тооны хавтан тавих болон хяналтын бүсийн зам талбайг тэгшилж янзлах ажлыг шат дараалалтай хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Компанийн ажилчдын ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх, ажлын чанар, чадавх, хариуцлагыг сайжруулах үүднээс ажилчдын цалинг өмнөх оны мөн үеийнхээс 10-30 хувиар нэмэгдүүлж, сарын дундаж цалин (838,710 төг) бүс нутгийн хэмжээнд мөрдөгдөж байгаа амьжиргааны баталгаажих түвшин (198,000 төг)-гээс 76,3 хувиар, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (420,000 төг)-нөөс 49,9 хувиар өндөр байна.

2020 оны санхүүгийн үйл ажиллагааг тус компани нь 271,739.6 төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь үйл ажиллагаа явуулж хувьцаат компани статустай болсноос хойш анх удаа өндөр ашигтай ажиллаж байгаа үйл явц болсон бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрээр 46,200,000 ширхэг хувьцааны нэгж хувьцаанд 5 төгрөг байхаар тооцон 231,000,000 төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаар шийдвэрлэлээ.

2.6. “Компанийн засаглалийн кодекс”-ын хэрэгжилтийн талаарх үнэлгээний тайлан

Тус компани нь “ Компанийн засаглалийн кодекс “-ийг мөрдөн дагаж ажиллаж байгаа бөгөөд өөрийн компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллээ компанийн өөрийн веб сайт, Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн бирж, Монголын Компанийн засаглалийн үндэсний зөвлөлийн веб сайтуудад тавьж олон нийт болон хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангаж байгаа болно.

3. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

3.1. Компанийн хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;

НББ-ийн дансны нэгдсэн зааврын дагуу үндсэн дансуудыг ангилан, туслах дансуудыг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан коджуулан хэрэглэж байгаа бөгөөд дансны жагсаалт нь баланс болон орлого, үр дүнгийн тайлангуудын дансуудаас бүрддэг. Санхүүгийн жилийн татвар ногдох орлого, зардлаа Монгол Улсын Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд бэлтгэн тайлагнадаг.

Санхүүгийн тайлангаа НББ-ийн аккрузл суурьд үндэслэн бэлтгэдэг ба холбогдох хуулийн дагуу татварын тайланг улирлын тайлангаа дараа сарын 20-ны дотор, жилийн тайлангаа дараа оны 2 сарын 10-ны дотор баталгаажуулан Төрийн сан болон Татварын хэлтэс, МХБ, СЗХ зэрэг байгууллагуудад хүргүүлдэг. Мөн бид санхүүгийн тайлангаа өөрийн веб сайтандаа байршуулдаг ба энэ нь манай дотоодын харилцагч нараас гадна дэлхийн аль ч улс орноос харилцагчид санхүүгийн мэдээллийг бодитой, шуурхай авах боломжийг олгодог.

Санхүүгийн байдал / Аудитлагдаагүй тайлан /

Үзүүлэлт	2020 оны 01-р сарын 01	2020 оны 12-р сарын 31
Эргэлтийн хөрөнгийн дүн	119,913.00	330,897.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,102,883.60	4, 896, 002.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,222,796.60	5,226,900.2
Өр төлбөрийн нийт дүн	427,540.72	159,884.7
Эзэмшигчдийн өмчийн дүн	4,795,255.90	5,067,015.5
Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	5,222,796.60	5,226,900.2

Орлого Үр дүн

Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	1,021,849.4
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0
Нийт ашиг (алдагдал)	1,021,849.4
Түрээсийн орлого	41,181.8
Хүүний орлого	107,4
Бусад орлого	180,737.0
Ерөнхий ба удирдлагын зардал	926,297.2
Санхүүгийн зардал	27,165.9
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	11,8
Бусад ашиг (алдагдал)	(12,300.0)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	278,125.0
Орлогын татварын зардал	6,365.4
Татварын дараах ашиг (алдагдал)	271,759.6
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	0
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	271,759.6

3.2. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл;

Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний гэрээ хэлцэл хийгдээгүй болно.

3.3. Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа, баталгаа гаргасан талаарх мэдээлэл

Огноо	Зээлийн төлөлт	Үлдэгдэл
Зээлийн эхний үлдэгдэл		164,000,000
20.01.01-20.12.31	36,000,000	128,000,000
Зээлийн үлдэгдэл 2020 оны 12-р сарын 31		128,000,000

Худалдаа хөгжлийн банкнаас 2018 оны 12-р сарын 17-нд 5 жилийн хугацаатай сарын 1,8%-ийн хүүтэйгээр авсан 200,000,000 сая төгрөгний зээлийн үлдэгдэл нь 128,000,000 төгрөг байна.

4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020.04.29-ний өдөр нийт хувьцааны 93.49% буюу 43,194,517 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэй хуралдсан. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

- Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаар төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.
- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэх асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0.00% татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.
- Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны цалин урамшууллын төсөв тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүдээр Э.Батболд, Ч.Энхболд, Ч.Амарсанаа, Б.Лхагвадорж, Д.Даянбилгүүн, Ш.Шинэбаяр нар, хараат бус гишүүдээр А.Цэнгэл, Ч.Оргил, Ж.Энхтулга нар сонгогдсон.

4.2. Компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл;

д/д	Овог нэр / хуулийн этгээдийн нэр /	Албан тушаал	Хувьцааны хувь
1.	Э-Транс ХХК	Ачаа тээврийн компани	50%
2.	Би Ди Сек ХК	Брокер дилер, андеррайтэрийн компани	28.5%
3.	Тасган инвест ХХК		11,08%

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болох Энхболдын Батболд, гишүүн Чулууны Энхболд, Бүрэнмэндийн Лхагвадорж, Данзангийн Даянбилгүүн, Шараагийн Шинэбаяр болон гүйцэтгэх захирал Чулууны Амарсанаа нар нь компанийн хараат гишүүд болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болох Алтангэрэлийн Цэнгэл, Жаргалсайханы Энхтулга, Чулуунбаатарын Оргил нар нь компанийн хараат бус гишүүд болно.

4.3. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн мэдээлэл;

Компани нь Э-Транс ХХК, БиДиСек ҮЦК ХК, Тасган инвест ХХК гэсэн 5%-иас дээш хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчтэй болно.

5. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

5.1. Компанийн тухайн жилийн ногдол ашгийн тухай;

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн гаргасан 01 тоот тогтоолоор компанийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагааны цэвэр ашгийн 85 хувь буюу нэгж хувьцаанд 5 төгрөгөөр 46,200,000 хувьцаанд нийт 231.000.000.00 төгрөгний ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн.